

Монгол хэлний «НЭГ» хэмээх үгийн тухай

Дийзгарын БАТТОГТОХ*

Монгени цогцолбор сургуулийн Эх өв, соёл судлалын
хүрээлэнгийн ЭНБД, Зөвлөх багш

Ганц үг гээд ганцахгүй. Дан ганц нэг үгийн судалгааг сүүлийн үед манай хэл шинжлэлчид сонирхон судалж байна. Нэг үгийн судалгааг эрдэмтэн Н.Нансалмаа “цогц ойлголт”, “цогц мэдлэг”-тэй холбон тайлбарласан бол эрдэмтэн Д.Бадамдорж танихуйн хэл шинжлэлийн цөм салбар бол танин мэдэхүйн утга зүй юм гээд мэдлэгээр илрэх танихуйн цогц ойлголтыг “багц мэдлэг” хэмээн үзжээ. Хэдийгээр нэг үг боловч түүний судалгааг хэлний бүтэц, хэл зүй, үгийн гарал зүй, утга зүй, найруулга зүй, хэрэглээний хэл зүй зэрэгтэй холбон судалбал багц мэдлэг, цогц ойлголт бүрнээ гарч, тухайн үгийн агуулгын багтаамж хүрээ, бүхэллэг утга, ухагдахууны илэрхийлэл, үг хэлээр илрэх хүний сэтгэлгээний олон талт байдал бүрнээ танигдах юм.

“Аливаа хэлний тооны үг (нэр) бол тухайн хэлний үгсийн санд томоохон байр эзлэн оршдог бие даасан аймаг болдог. Энэ нь тоо, хэмжээс бол хүн төрөлхтний өдөр тутмын эртний хэрэглээний нэг байсантай холбоотой.”

Иймд бид энэ өгүүлэлд “нэг” хэмээх тооны нэрийг сонгон авч, түүний тухай цогц ойлголт, мэдлэг, ухагдахууны илэрхийллийг монгол хэлний бүтэц, хэл зүй, утга зүй, найруулга зүй, гарал зүй, хэл соёлын үүднээс судалж, үүр үгс, бүлэг багц үгийг үүсгэж, хэл шинжлэлийн олон салбар ухааны үүднээс нягтлан судлав. Юуны өмнө “нэг” хэмээх тооны үгийн утгыг “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”-д хэрхэн тайлсныг үзье.

Нэг(эн)-1. Хамгийн бага бүхэл тоо: дан ганцаар байгаа зүйл, үндсэн тооны эхнийх нь, 2. Дан нэг төрлийн, хольцоогүй: **нэг ай** (ганц аймаг, бүлэг, ганц хэсэгт багтах), **нэг аймаг** (аймгаар хуваасан хуваарь), **нэг төрлийн бараа** (ганц төрлийн бараа бүтээгдэхүүн), **нэг үе** (нас ойролцоо), **нэг талыг баримтлах** (ганц талыг нь өрөөсгөлөөр баримтлах), **нэг нэгээр нь зурах** (ганц ганцаар цувуулан зурах), **нэг энд, нэг тэнд** (хаа сайгүй), **нэгд нэгэнгүй** (нэг бүрчлэн, тодорхой), **аль нэг** (тодорхой бус зүйлийг заан нэрлэсэн нь), **нэг гэрт багтах** **аа болих**-таарч тохирохгүй болох, **нэгийг хоёр болгож, нимгэнийг зузаан болгох**-

* © Д.Баттогтох 2024

эд хөрөнгөтэй болох, баяжих, сүйхээтэй авхаалжтай байх, 3. Сарын эхний өдөр: есдүгээр сарын нэгэн, 4. Нэгж хэм, хугацаа: нэг жил, нэг өдөр, **нэг мөч** (цагийн хэмийн нэр, арван таван минут), **нэг хувь** (цагийн хэмийн нэр, секунд), 5. Ондоо бус адил, ижил: **нэг адил саналтай байх** (бусдын саналыг зөвшөөрөн дэмжих), нэг иж (нэг бүрэн бүтэн юм), **нэг санаатан** (үзэл бодол нийлэх хүн), **нэг үзүүрт сэтгэл** (ямар нэгэн ажил хэрэгт эргэлт буцалтгүй тууштай зүтгэхээр шийдсэн нь), 6. Аливаа үйл явдлыг хамт, зэрэг хийх нь: **нэг дор ажиллах** (хамт ажиллах), **нэг тогооноос хоол идэх** (нэг гэрт амьдрах), 7. Дахин: **бас нэг дуулах** (дахин дуулах), 8. Яриа. Ганц удаа, түр зуур: **нэг хэлэх** (нэг удаа хэлэх), **нэг жаахан унтах** (түр зуур унтах) гэхчлэн 8 өөр утгат үгийг жишээгээр тайлбарласныг үзвэл, “нэг” гэх үгийн утга өргөн дэлгэр, олон салаа салбар, сүеэ сүлбээтэй, үүр үг ихтэй ажээ.

“Нэг” хэмээх үндсэн тооны нэр нь үг холбох, нийлэх, хорших, найруулах аргуудаар үгсийн аймгийн ихэнх үгтэй холбогдож, өвөрмөц олон холбоо үг, хоршоо үг, хэлц үг үүсгэж, хэл найруулгыг тэгш хэмт, олон утгат, иж үгтэй болгож байгаа нь түүний үг бүтээх чадавх, идэвхийг харуулна.

“Нэг” гэдэг үг хэл зүйн байр, харьцаагаараа холбогдож байгаа үгийнхээ өмнө буюу ард нь орж, олон холбоо үг, хоршоо үг, хэлбэржсэн үг, хэлц үг, бусад айн үгийг үүсгэж, бүтээж байна. Энэ нь монгол хэлний үгсийн сангийн баялгийг илтгэх төдийгүй эл үгийн нийлц, холбоц, хэлхэц, хэлмэрийн олон талыг харуулах баримт юм. Ингэж олон холбоц, нийлц, хэлхэцээр үүссэн “нэг” бүхий холбоо үгийг тооны нэрийн зүйл, үгсийн сан, үгсийн аймаг, утга зүй зэргээр зүйлчлэн хувааж, түүн түүвэрлэвэл үлэмж их тоотой байгаа нь тухайн үгийн онцлог, гарал үүсэл, утга найруулга, хэрэглэгдэх хэрэгцээ, шинэ үг үүсгэх чадвар, илтгэх утга санаа зэрэгтэй холбоотой давуу тал юм. Тухайлбал:

1. Тооны нэрийн зүйл: **Үндсэн тоо:** нэг ном, **Дэс тоо:** нэгдүгээр сургууль, нэг дэх өдөр, **Түгээл буюу тойм тоо:** нэг нэг, нэгжгээд, **Бутархай тоо:** мянганы нэг, гуравны нэг, **Дахих тоо:** нэг удаа, нэг дахин, **Тодорхойгүй тоо:** нэлээд гэх мэт.

2. Хэл зүйгээр хэлбэржсэн үг:

-**Тийн ялгалаар:** **нэг** (нэрлэх), **нэгийн** (тоо), (харьяалах), **нэгийг** (авах) (заах), **нэгд** (өгөх орших), **нэгээс илүү** (гарах), **нэгээр дутуу** (үйлдэх), **нэгтэй тэнцэх** (хамтрах), **нэг рүү нь очих** (чиглэх) гэх мэт.

-**Хамаатуулахын нөхцөлөөр:** **нэгийгээ, ганцаасаа,** Жишээ нь: “Өгье гэвэл ганцаасаа”

-**Дагаврын аргаар:** **нэг-т, нэг-ж, нэг-мөсөн, нэг-бүрчлэн, нэг-энт, нэгэн-тэйгүүр, нэг-жих, нэг-дэх, нэг-дэл, нэг-дүүл, нэг-сэх, нэг (ж)-гээд** гэх мэт. “Нэг” гэсэн үг дагавар болж хувьссан нь олон монгол хэл аялгууны зарим аялгуунд тухайлбал баоань, монгор хэлэнд нэр үндсэнд “-нгэ, -гэ” гэсэн дагавар залгаж, ганц тоог илтгэдэг хэл зүйн өвөрмөц арга бий. Жишээ нь: баоань хэлэнд дэдэ “өвгөн” дэдэнгэ “нэг өвгөн”, монгор хэлэнд **йага** “аяга” йаганга “нэг аяга”, дээрх хоёр хэлэнд мөн **кун** “хүн” кунгэ “нэг хүн” гэх мэтээр “нэг”

гэсэн ганц тооны утгыг илрүүлдэг. Энэ бол монгол хэлний “нэг” гэсэн тооны нэр дагавар болж хувьссан үзэгдэл юм. Дээрх хэлнүүдээс өөр бусад монгол хэлэнд нэр үгийн ганц тоог тусгайлан илрүүлдэг дагавар үгүй” гэж Ц.Өнөрбаян нар үзжээ.

Үгсийн сангийн үгсээр үүссэн нэгийн тооны нэр:

-*Үйл үгээр: нэг+ж =нэгж (нэгжих), нэг+д=нэгд (нэгдэн нийл), нэгдтүгэй, нэгдэгтүн, “Эвлэлдэн нэгдэгтүн!”* гэх мэт.

-*Тэмдэг нэрийн үүргээр: Хүний сэтгэлийн өнгө аяс илэрхийлэхэд -хан (-хэн, -хон,-хөн) гэсэн тэмдэг нэрийн бууруулах зэргийг хэрэглэж, чамласан, хязгаарласан тоон утга илэрхийлнэ. Жишээ нь: Надад нэгхэн алим үлджээ. Ганцхан чамдаа би хайртай. (дуунаас)*

-*Төлөөний нэрийн үүргээр: тус бүр, аль нэг, ганц нэг нь, нэгнийх нь, нэг маань, нэг минь* гэх мэт.

-*Өвөрмөц хэлц үгээр: нэгд нэгэнгүй (нэгжих), нэгийгээ үзэх, талаар нэг тархах, газар дээр ганц, нэг гишүүнт гэр бүл* гэх мэт.

-*Хэвшмэл хэлц хэллэгээр: Жишээ нь: “Нэгийгээ үзэж, нэхий дээлээ тайлах”, “Нэр нэгтийн чих нэг”, “Нэг настай, нялх сэвлэгтэй”, “Эр хүн нэг үгтэй, эмээл найман ганзагатай”, “Нэг нь нийтийн төлөө, нийт нь нэгийн төлөө”, “Нэгэн амаар айлдаж, мянган сонорт хүргэх”, “Нэмж бодоход нэг үг дутахгүй, хасаж бодоход нэг үг илүүдэхгүй”, “Нэгийн хүч, ганцын мөхөсдөл”, “Нэг бүдэрвэл долоо бүдрэх”, “Нэг чихээрээ сонсоод, нөгөө чихээрээ гаргах”, “Га Ха-гаар нийлээд Ганжуур Данжуур болдог, Ганц хоёроор нийлээд түм бум болдог”, “Тоонь бие, гозон толгой”, “Нэг сонссоноо мартахгүй, нэг үзсэнээ андахгүй”, “Алдсан хүн арван тамтай (нүгэлтэй), авсан хүн нэг тамтай (нүгэлтэй)”, “Муу эхнэр нэг насны гай”, “Нэг хүний үгээр олон юм хямрах нь бий, нэг хүний үгээр олон юм эвсэх нь бий”, “Нэгийн гай мянгад”, “Нэг цагийн эндүүрлээс нэгэн насны гэмшил болох” гэх мэт.*

-*Гадаад үгээр: еще нэг, нэгийн цифр, ромбоор нэг (I)* гэх мэт.

-*Сул үгээр: нэг ч хэлгүй (гадаад хэлгүй), нэг шүү* гэх мэт.

4. Утга зүйн үүргээр орсон нэгийн тооны нэр

-*Баймж утгатай нэгийн тооны нэр: нэг л сайхан, нэг л гоёхон, Жишээ нь:*

Хар ус нуурын шагшуурга

Намрын салхинд исгэрнэ

Харахад нэг л уйтгартай

Намс намс бөхөлзөнө (Б.Явуухулан. “Хар ус нуурын шагшуурга”) Намрын хүйтэн хуйсгануур салхинд нуурын зэгс шагшуурга нэгэн хэм, хөдөлгөөнөөр шуугин исгэрч, найган бөхөлзөх нь хүний сэтгэлд уйтгар төрүүлэхийг “харахад нэг л” гэсэн баймж үгээр илэрхийлжээ.

-*Хүчжүүлсэн утгатай нэгийн тооны нэр: (нээг-хоёрын гурваа),*

-*Дүрслэг буюу адилтгал үгтэй нэгийн тооны нэр: нэг адил, нэгийн тоо лугаа дүрс, Жишээ нь: зоосны нэг тал нөгөөтэйгөө адил* гэх мэт.

-Оруулсан үгийн бүрэлдэхүүнд орсон нэгийн тооны нэр: **нэг мэдэхэд, нэг санахад**. Жишээ нь: “Ийш тийш бүртийсэн сэргийсэн юмыг харж явсаар, **нэг мэдвэл**, хэдэн арван газар дэв дэмий явсан байв” (Д.Нацагдорж. “Харанхуй хад” зохиолоос). Нэг нь зөвхөн “мэдэх, санах” гэсэн үгтэй хоршиж, хэл найруулгад өгүүлэгчийн бодол сэтгэлийн өнгө аяс илэрхийлэх үүргээр ордог онцлогтой бол үүнийг “хоёр мэдэхэд”, “тав санахад” гэж өөр тооны үгээр солин найруулж болохгүй.

-*Доромж утгатай нэгийн тооны нэр: өрөөсөн, доён, ончин*, Жишээ нь: Доён-гон бие, гав ганц, -Олонгүй бол доён. (Л.Түдэв. Нүүдэл.)

-*Хүндэтгэл утгатай нэгийн тооны нэр: магнайлах, түүчээлэх, тэргүүлэх* гэх мэт.

-*Үгүйсгэх утгатай нэгийн тооны нэр: нэг ч үгүй, нэгийг ч үл мэдэх* гэх мэт.

-*Ойролцоо ба төсөөт утгатай тооны нэр: ганц, гань, гоонь, өрөөсөн, сондгой, цорын, анх, анхдугаар, тэргүүн, түрүүн, дан, нэгийн хагас (0,5)* гэх мэт.

-*Хоршоо үгээр: ганц нэг, гань ганц, цор ганц, нэг нэгээр, нэгтийн дэвсгэрт (мөнгө), нэгэн зүйл, нэгэн санаат, нэг дор, шинийн нэгэн, хэн нэгэн* гэх мэт. Жишээ нь: “Ганц дээлт барилдаанч, ганц морьт уралдаанч” (Зүйр үг)

Энэ мэтчилэн “нэг” гэх дан үгийг өөр өөр үгтэй холбож, үгсийн хэлхээ үүр үүсгэхэд олон чөлөөт ба чөлөөт бус холбоо үг (хоршоо үг) үүсэж байгаа нь эл үгийн хэрэглээний онцлог, найруулах боломж, шинэ үг үүсгэх чадварыг илтгэнэ. Холбоо үг гэдэг бол үгийг өгүүлбэртэй холбох хэлний гол холбоо бөгөөд үг, өгүүлбэр гэсэн хэлний үндсэн нэгжийн завсарт байх “завсрын нэгж” болно. Энэ нэгжийг монгол хэл зүйн бичгүүд, судалгаа шинжилгээний ном зохиол, сургуулийн хэлзүйн сурах бичигт “нийлэмж үг, нийлмэл үг, хошоод үг, хос үг, хам үг, хэмт үг, хоёрлосон буюу хосмолжин нэр” гэх мэтээр нэрлэсээр иржээ.

Нэг нь ганц тоог заах утгатай тооны нэр боловч бүх юм нэгээс эхлэлтэй тул утгын өргөсөл, гүнзгийрэл, тэлэлт, өөрчлөлт нь өргөн хүрээтэй, үгийн нийлц, хэлзүйн зохицол нь олон талтай, найруулах хэв маяг нь өөр өөр юм.

Монголчууд юмны эхлэлийг бэлгэдэх сэтгэлгээтэй тул нэгээс эхтэй тоон утгыг “тооны суурь” хэмээн үзэж, “нэгтийн орон”-оос эхэлж, цааш нь аравт, зуут, мянгат, түмт, бумт... гээд нэгийг аравтын орноор олшруулж, нэгдэн нягтрахын ид хавыг илэрхийлсэн утга бэлгэдэлтэй тоог үүсгэжээ. XIII зууны үеийн монголчуудын цэрэг, иргэний байгуулалт нь аравтын тогтолцоотой байв. Тэрхүү аравтын тооны урд ямагт нэгийг дурддаг. Тухайлбал, нэг зуут (100), нэг мянгат (1000), нэг түмт (10000)... гэх нь “нэгийн тооны томруулсан дүр” (С.Дулам) бөгөөд ердөө л арван хүн нэгэн бие болж чадваас ертөнцийг эзэлж чадна гэсэн чанд утгаар ухаж, цэрэг, иргэний байгуулалтаа нэгээс эхтэй аравт, зуут, мянгат болгон хуваарилж байжээ. Эдүгээ энэ уламжлалыг Монгол Ардын Хувьсгалт Нам (намын дарга Н.Энхбаяр) өвлөн авч, нам доторх гишүүд, иргэдийн зохион байгуулалтаа ингэж хийсэн нь “эвтэй байхдаа хүчтэй” гэсэн үзэл баримтлалтай

нь зохирон нийцсэн гэдгийг дашрамд өгүүлэе.

Угаас цор ганцыг, анхдагч тоог заах “нэг”-ийн утгыг аман ба бичгийн хэлний найруулгад олшруулан хэрэглэж, хэлний хэмнэлтийн зарчмыг алдагдуулж байгааг хэл шинжлэлийн эрдэмтэд тухайлбал, Ш.Барайшир “...олны дагаврыг хамаа бус хэрэглэх явдал үзэгдсээр байгаа”, Чой. Лувсанжав “Олон тооны дагавар олширвол олигтой орчуулга болохгүй”, Д.Отгонсүрэн “Үг нь утгаараа олны санаа заах, эсвэл үг үгтэйгээ нөхцөлдөж олны санааг илтгэдэг тохиолдолд олон тооны дагавар авахгүй”-г анхааруулан бичжээ. Гэтэл ерийн хэлэлцэхэд ямагт ганц тооны утгаар хэрэглэдэг нэр үгсийг зориуд олшруулж, тухайлбал охин-д\-ууд, нөхөр-д\-үүд, од-д\, адуу-н\-ууд, хонь-д\-ууд бэлчих гэж олон тооны дагаврыг илүүц хэрэглэх нь дагавар илүүдүүлсэн найруулгын алдаа болно.

“Нэг” гэдэг үгийн хэл зүйн зохицол нь: нэг гэх үг өмнөө, хойноо тодотгол авч, үгсийн аймгаар хувирахдаа жинхэнэ нэр, тооны нэр, тэмдэг нэр, төлөөний нэр, үйл үг+нэг=нэр **нэгтэй, гуравны нэг, талын** (орон заасан тэмдэг нэр) **нэг, таных нэг, түрүүлсэн нэг** гэх буюу нэг+ жинхэнэ нэр, тооны нэр, тэмдэг нэр, төлөөний нэр, үйл үг=**нэгний өглөө, нэгэн жаран, нэг хүрэн (ат), нэгдэх минийх, нэг нь яв** гэх мэт.

“Нэг” гэх үгийн тооны **бэлгэдэл утга** нь: юуны түрүүн үгсийн сангийн утгаар илэрч байна. Энэ тухай бэлгэдэл зүй судлаач эрдэмтэн С.Дулам бичихдээ: “Нэгийн тооны бэлгэдэл утга нь: нэгдэн нягтрахын ид хав (ни-, нигэ), ангид салангидын мөхөсдөл (гани, гагц), ганц бие, сэтгэлийн зовлон (гон, гоонь), үнэмлэхүй ганц (цор гагц) хийгээд хос хослолын нэгэн (өрөөсөн, өрөөл), эсвэл тооны үлдэл (сондгой), цагийн утга (анх), хүн (тэргүүн), амьтан, ургамлын (түрүү) дээд биеийг тэмдэглэсэн олон өнгө аястай байна” гээд цааш нь “Нэгийн тоо бол сондгой тоо болон түүний бэлгэдлийг үүсгэгч бүтвэр махбод юм. Хос хосоор нь тоолоход нэг илүүдэн үлдэх өрөөсгөл буюу сондгой тоо нь “олноос онцгойрч”, “цөөнөөс цөмцийж”, “хэсгээс хэлтийж” (“Агийн улаан хаан” туулиас) нэг нь үлдэхийг сондгой хэмээн нэрлэсэн ажээ. “**Ни-**” язгуурт нэгийг тэмдэглэсэн үгс нь цул бат нэгдлийг, “**га-**ни\”, “**го-**онь\” язгуурт үгс нь ганцаардал доройтлыг тэмдэглэхээс эхлэн нэгийн тоогоор андын барилдлагын эв санааны нэгдлийг болон хам олны эв эеийг бэлгэддэг бөгөөд нэгээс олон, олноос аравтууд үүсэх учир зүй, арга билиг тоо, тэгш сондгойн чанад утга-бэлгэдлийн нууц нь зөвхөн нэгийн тоотой холбоотой ажээ” гэсэн дүгнэлт хийжээ.

Одоо “нэг” хэмээх үгийн гарлыг эрдэмтэд хэрхэн тайлбарласныг үзье. Академич Д.Төмөртоогоо “Монгол хэлний үгийн гарлын тайлбар толь”-доо: “Нэг \nigen\ = [*nig-e-n] 1x1=1 \|Ж=tende ber nigen suburgan bosgaju ejij-e-de kars-a degel abuysan suburyan kemen nereyidumui [тэнд нэг суварга босхож эдүгээ хүртэл шар нөмөргөт суварга хэмээн нэрлэгдсээр] (Burx. 25b). Энэхүү язгуураас nigede- [nige-de] нэгд-, nigeji [nige-ji] нэгэж, nigeji- [nige-ji] нэгж- гэх мэт үг үүсжээ. \| Kha. neg, Ord. nige, Bur. nege, Oir. neg.n.

(Товчилсон үгийн тайлбар: Burx.-Бурхан багишийн арван хоёр зохионгуй.,

Kha.-Халх аялгуу., Ord.-Ордос аялгуу., Oir.-Ойрад аялгуу)

Монгол хэлний нэгээс арав хүртэлх тооны нэрийг аравтын тогтолцоотой нь харьцуулахад нэг язгууртай болохыг эрдэмтэд нэгэнт тогтоожээ. Тухайлбал, Г.И.Рамстедт, Н.Н.Поппе нар “ни-гэ-н” (нэг) хэмээх үгийг нэ-жи-гэ-н, ни-жи-гэ-д (нижгээд),

	нэ-йи-с-	(нийслэл)
	нэ-йи-д-гэ-	(нийт \д\-гэ)
нэ-йи-дэ,	нэ-йи-гэ-	(нийт)
	нэ-йи-чэ-	(нийц)
	нэ-йи-лэ-	(нийц-)
	нэ-йи-лэ-	(нийл-)
	ни-д-кере-	(нитгэр-) зэрэг “нэ-, ни-“ язгуур

бүхий үгээс эхтэй гэж үзжээ.

Монгол үгийн гарлыг нарийн нягт судалсан эрдэмтэн М.Базаррагчаа багш “Монгол үгийн гарлыг мөшгөх нь” хэмээх 5 боть дорвитой бүтээлийнхээ тэргүүн ботид “Нэгээс арав хүртэлх тооны нэр”-ийн гарлыг судлан үзэхдээ: “Ни-(нэг), нэ-(нээх), на-(найр, наа-), но-(ноохой, ноолуур), ну-(нуур)” язгуур бүхий үгс нь “нэг цул” буюу “салахгүй зууралдсан” хэмээх утгатай бөгөөд “Нэг адилхан морь, нэг дор ирэх” гэх мэтээр хэлэлцэх нь “нэг” гэсэн үг нь “хамт, нэгдмэл” гэсэн утгатайг гэрчилж байна гээд, цааш нь монгол хэлтэй төрөл хэлнүүдэд, тухайлбал, хамниган (хами-ни-га-н хэмээх эл нэр нь хами (Алтайгаас баруун тийших газрын нэр \ни-га-н\ тэрхүү хами нутгийн нэг хэсэг) гэсэн хоёр үгээс бүтсэн (Д.Г.Дамдинов), киргиз хэлнээ нэг-ийг “йикэ” \ганц\ гэж “и”-гээр сэлгэн хэлдэг (Г.И.Рамстедт) гэдгийг “ни-гэ-н” хэмээх үгийн гаралтай холбогдуулан дурджээ. Эртний монгол хэлэнд “нийлж хамтарсан нэг юмыг “нэ-йи-гэ-н” гэж хэлж байснаа, “нийлж хамтарсан” хэмээх утга нь “нэг цул” гэсэн утгаар яваандаа солигдох болсон тул “-йи” бүтээвэр гээгдэн, улмаар “нэ-гэ-н, ни-кэ-н” гэх зэргээр хэлэгдэх болсон байна” гэж тайлбарлажээ.

Монголчууд эрт үеэс тоог түүнд харгалзсан тоотой юмны нэрээр нэрлэж байжээ. Жишээ нь: нар, сар нь орчлонд ганц байдаг гэж үзээд “**нэгийг нар, сар**” гэж **төлөөлөн** нэрлэж байсан байна. “Мэргэд гарахын орон нэрт даяг” хэмээх номд “нэг” гэж нэрлэхийн оронд “**наран, саран**” гэсэн үгийг хэрэглэнэ гэж тэмдэглэсэн бол “Монголчуудын дээд математик” номд 64 оронтой тооны нэрийг бичээд, нэгийг “**толыг саран**” гэдэг үгээр нэрлэсэн байх жишээтэй. Ингэж монголчууд тоог үгээр нэрлэж байсан нь сонин баримт бөгөөд тооны гарал үүслийг сонирхон судлахад анхаарч үзүүштэй санагдана.

“Нэг” гэдэг тооны нэр нэг өгүүлбэрт хэчнээн олон байвч найруулгыг үлбэгэр сул болгодоггүй, харин ч өөр өөр утгыг илтгэж тодорхой болгосон байна. Жишээ нь, “Тэднийг нэгд нэгнээр ажиглавал **нэг хөх царайтай** хижээл хүн, **бас нэг** хар хүн, **нөгөө нэг** хүн нь нас залуу” (Д.Нацагдорж. “Үзээгүй юм” өгүүллэгээс) гэсэн өгүүлбэрт байгаа “нэгд нэгнээр” гэсэн давтамал хоршоо үг нь олны утга

юм уу, тоочсон санааг илэрхийлсэн бол “нэг хөх царайтай хүн” гэхэд ганц гэсэн үндсэн утгаар, харин дараагийн “бас нэг хүн” гэх холбоо нь дахин давтсан, утгыг ахиулсан үүрэгтэй оржээ. Тэгвэл сүүлийн хэсэгт байгаа “нөгөө нэг” нь өөр бас нэг хүн гэж олноос ялгасан утгаар оржээ. Хураангуйлбал, тус өгүүллэгийн нэг л өгүүлбэрт “нэг” хэмээх тооны нэр 4 удаа давтагдсан боловч үүнийг нэг үгийг олон удаа давтсан, найруулгыг сул сулбагар, өгүүлбэрийг урт сунжруу болгосон гэж шүүмжлэн үзэхгүй, харин “тэд” гэх олны утгыг тус бүрийд ялгаж, хүн нэг бүр нь өөр өөр зүс царайтай, хөгшин залуу болохыг тодорхой өгүүлжээ.

Зохиолч Ч.Лодойдамбын “Солонго” өгүүллэгт “нэг” гэдэг тооны нэр бүхий нийлэмж үг 26 байгаа нь өгүүллэгт орсон бүх тооны нэртэй үгийн 75 хувийг эзэлсэн байна. Энэ нь “нэг” гэх үг хэл найруулгад, ялангуяа ярианы болон уран зохиолын найруулгад олонтоо ордог идэвхтэй үг, найруулгад ихээхэн чухал үүрэгтэй болохыг илтгэж байна.

Нийт хүн бүгдээр

Нэг гэрийн ах дүү мэт

Нийлж ажлаа бүтээх

Нийгэм журам тогтож байна (Ц.Дамдинсүрэн “Буурал ээж минь” шүлгээс) гэсэн нэг бадаг шүлгийн толгойг “ни-, ний-, нэ-” гэх үе бүтээврээр холбосон нь цөм “нэг”-ийн утгатай ажээ.

Монгол хэлний аман болон бичгийн найруулгад “нэг”-ийг ийнхүү илүү их хэрэглэж байгаа энэ үзэгдлийг “хэлний илүүдэл” (избыточность в языке) гэдгээр тайлбарлан, хэлэнд байгаа нэг сонин үзэгдэл гэж үзвэл зохилтой. Жишээ нь: аман ярианд “За би, **нэг сайн** цай ууя”, “Надад **нэг хэлэх** үг байна” гэсэн өгүүлбэрт байгаа “нэг” нь ганц аяга цай уух, нэгхэн үг хэлэх гэсэн утга санаа бус, ер нь л цайгаа тавтай ууж цайлъя, чухал үг ярьж, санаагаа хэлье гэсэн утга илэрхийлж байгаа тул дээрх үгийг хэл найруулгад “үг илүүдсэн алдаа” гэж хасах ёсгүй, харин ч баймж утгыг илэрхийлсэн өгүүлбэр, хүний сэтгэлийн өнгө аяс, бодит байдалд хандсан өгүүлэгчийн санаа бодлыг илэрхийлсэн “чухал хэрэгтэй үг” гэж үзүүштэй.

Ер нь монгол хэлний бусад хэлнээс (төрөл бус хэл) ялгарах нэг ялгаа нь тоог заахад илрэх бөгөөд энэ нь монгол хүний хэл, сэтгэлгээний онцлогтой холбоотой юм. Монгол хүн аливаа юм, үзэгдлийг тухайлбал тоог тусгайлан ялгаж нэрлэх (орос хэл, англи хэл шиг ялгац гишүүн \радикал\ хэрэглэхгүй)-ээсээ ерөнхийлөн нэрлэх нь түгээмэл байдаг. Энэ тухай эрдэмтэн Т.Дашцэдэн бичихдээ “Орчин цагийн монгол хэлэнд ерөнхий тоотой эсрэгцэл байдалтай тодорхой тоо байдаг. Нэгэнт ерөнхий тоо нь түгээмэл байдалтай байдаг тул... ерөнхий тооны суурин дээр тодорхой тоог ялгах ёсон хэвшсэн ажээ” гээд “Хэрэв нэрийн ганц тоог тодорхой болгох шаардлага тулгарвал, ерөнхий тоот нэрийн өмнө ганцын санаа заах үг холбож үзүүлнэ. Тухайлбал, “Ганц хүн айл болдоггүй, ганц цучил гал болдоггүй”, “Нэг өдөр танилцаад, мянган өдөр нөхөрлөнө” гэсэн жишээ авчээ.

“Нэг” хэмээх энэхүү дан гагц үг нь хэл найруулгад хэрэглэгдэхдээ дээр

дурдсан мэт олон утгатай, янз бүрийн хэв маягтай, өөр өөр хувиралтай болж байгаа нь тухайн үгийн “өөрчлөхүй, хөрвөхүй” (үүнийг хэл шинжлэлд **conversion-конверсия**⁸ гэсэн нэр томъёогоор хэрэглэдэг. Д.Б.)-н чадвартай холбоотой болно.

Нэгийн тооны бэлгэдэл утгын тухай “Монгол судлалын нэвтэрхий толь” -д бичихдээ: “Ардын тоглоомын үгэнд “Нэг гэж юу вэ? Нэг хэлснээ мартахгүй”-гэх бол аж ахуй, амьдралын явцад адуу малын тоог нэг азарга адуу, нэг сүрэг хонь гэх, аян жинд яваа хэд хэдэн хүнийг нэг гал аян хийх гэх, ёслол үйлийн ажиллагаанд өргөл мөргөл хийж хадаг өргөхдөө нэг хадаг барих (татах) гэх, архи сархад барихдаа гурвыг нэгээр товчлон төлөөлүүлдэг, Онцгойрч ургасан ганц модыг шүтэж тахих, өнчин ганц хүн амьтныг өрөвдөх зэрэг нь нэгийн тооны бэлгэдэл ойлголтод агуулагдаж байгаа олон утгын жишээ юм” гэжээ. (Хөх хот. 2012.)

Цаашид энэ мэт “нэг” гэх үгтэй адил, монгол хэлнээ илүү их үүрэг үйлдэлтэй, хувирал өөрчлөлттэй, идэвхтэй хэрэглээний НЭГ ҮГ-ийг тал бүрээс нь нарийвчлан судалж, үгийн салбар утгасыг зохих хэмжээгээр нарийн гаргаж, түүний салбар утгад дүйх оновчтой үгийг сонгон олж найруулах, утга шилжсэн, салаалсан, хийсвэрлэсэн нэрийг тодруулах зэргээр утга зохиолын хэлний баялаг эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан, хэлний баримт жишээгээр байцаан тайлбарлаж судалбал хэл, угсаа, соёл, сэтгэлгээний олон сонин баримт гарч, монгол хэлний хэрэглээний судлалд чухал ач холбогдолтой болохыг онцлон тэмдэглэе.

Дүгнэлт

Сүүлийн үед хэл шинжлэлийн судалгаа шинэ шатанд дэвшиж, танихуйн хэл шинжлэл, сэтгэц хэл шинжлэл, нийгэм хэл шинжлэл, хэрэглээний хэл шинжлэл, хэл-соёл, хэл-заншил, хэл-угсаа гэх зэрэг биеэ даасан салбар ухаанаар баяжин хөгжиж байна. Мөн нэг үгийн “өөрчлөхүй, хөрвөхүй” (conversion-конверсия)-н судалгаа ч хийгдэж байна.

Бид энэ өгүүлэлд “нэг” хэмээх үндсэн тооны нэрийг сонгон авч, түүнийг монгол хэл шинжлэлийн бүх салбар ухаантай холбож, танихуйн хэл шинжлэлийн үүднээс багц мэдлэг, цогц ойлголтыг илрүүлэн тайлбарлахдаа хэл шинжлэл, хэлний зүй, үгийн гарал зүй, үгийн сан, бэлгэдэл зүй, утга зүй, найруулга зүй, хэрэглээ, соёл, угсаа, заншил зүйн ухаантай холбон судлав.

Цаашид хэл судлалд нэг үгийн судалгааг хөгжүүлэе.

Abstract:

Recently, linguistic research has advanced new level, leading to the emergence of specialized fields such as cognitive linguistics, psycholinguistics, sociolinguistics, applied linguistics, language-culture studies, language-customs studies, and language-ethnicity studies. Additionally, focused research on specific linguistic phenomena, such as word conversion, is being conducted.

In this article, we selected the basic number "one" and explored its relevance across various branches of Mongolian linguistics. We uncovered a wealth of knowledge and complex concepts through the lens of cognitive linguistics, addressing aspects such as etymology, vocabulary, symbology, and meaning. Our study also examined the term's connections to ethics, composition, usage, culture, ethnicity, and customs.

Ном зүй

- Базаррагчаа, М.** (1992). *Монгол үгийн гарлыг мөшгөх нь*. I боть. Улаанбаатар: хуудас 176. [Bazarragchaa, M. *Mongol üginn garliig möshgöh ni*. [Tracing the Origin of Mongolian Words]. Volume I. Ulaanbaatar: p. 176. 1992]
- Бадамдорж, Д.** (2018). *Танин мэдэхүйн утга зүйн удиртгал*. Улаанбаатар: хуудас 44. [Badamdorj, D. *Tanin medehüin utga züin udirtgal* [Introduction to Cognitive Semantics]. Ulaanbaatar: p. 44. 2018]
- Барайшир, Ш.** (1972). “Олон тооны дагаврын учир” ШУА сэтгүүл, №4. [Baraishir, Sh. *Olon toonii dagavriin uchir*: [Issue on the Suffixes of Plurality], Journal of the Mongolian Academy of Sciences, No.4.1972]
- Бат-Ирээдүй, Ж.** (2010). *Монгол хэлний тооны болон хэмт үгийн сан*. Улаанбаатар., х.3. [Bat-Ireedui, J. *Mongol helnii toonii болон hemt ügiin san*. [Lexicon of Numerals in Mongolian Language], Ulaanbaatar., 2010, p. 3. 2010]
- Батжаргал, Д.** (1965). *Монголчуудын дээд математик*. УБ., хуудас.113. [Batjargal, D. (1965). *Mongolchuudiin deed matematik*. [Upper Mathematics of the Mongolians]. Ub., p. 113. 1965]
- Дашцэдэн, Т.** (1980). *Орчин цагийн монгол хэлний нэрийн тоо*. УБ, хуудас.37,39. [Dashtsedен, T. *Orchin tsagiin mongol helnii neriin too*. [The Number of Nouns in Modern Mongolian]. Ub., p. 37,39. 1980]
- Дулам, С.** (2007). *Монгол бэлгэдэл зүй*. Тэргүүн дэвтэр, Тооны бэлгэдэл зүй, УБ, хуудас.28,35 [Dulam, S. *Mongol belgedel züi*. Terguun devter. [Mongolian Symbology]. First volume, Numerology, UB, pp.28,35. 2007]
- Лувсанжав, Чой.** (2013). *Нэр томъёоны цуврал бичиг*. Дахин хэвлэл. (Хэл шинжлэл), УБ. Luvsanjav, Choi. *Ner tomyonii tsuvral bichig*. Dahin hevlel. [Terminology series]. Reprint. (Linguistics), UB. 2013]
- Лувсанжав, Чой.** (1955). “Орчуулагч нар анхаарууштай гурван зүйл”, Соёл, утга зохиол, №8. [Luvsanjav, Choi. *Orchuulagch nar anhaaruushtai gurban züi*. Soyol, utga zohiol. [“Three things that translators should pay attention to”, Culture, Literature], No. 8. 1955]
- Хамтын бүтээл** (2008). *Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь*. II боть, УБ, хуудас.1425-1426. [Collaborative work. *Mongol helnii delgerngüi tailbat toli*. [Detailed dictionary of the Mongolian language]. Volume II, UB, pp.1425-1426. 2008]

- Хамтын бүтээл** (2012). *Монгол судлалын нэвтэрхий толь*, Зан үйлийн боть. Хөх хот. хуудас.203. [Collaborative work. *Mongol sudlaliin nevterhii toli*. Zan üi-liin boti. [Encyclopedia of Mongolian Studies], Volume of Rituals. Khokh khot. p.203. 2012]
- (ХҮП зуун)**, *Мэргэд гарахын орон нэрт даяг. Бичмэл судар*. [XXII century. *Merged garahiin oron nert dayag*. [Merged garahiin oron nert dayag]. Manuscript sutra]
- Нансалмаа, Н, Долгор, С.** (2014). *Танихуйн хэл шинжлэл*. УБ, хуудас.44. [Nan-salmaa, N, Dolgor, S. *Tanihuin hel shinjlel*. [Cognitive linguistics]. UB, pp.44. 2014]
- Рамстедт Г.И.** (1957). *Введение в алтайское языкознание*. М, настр.189. [Ramst-edt G.I. [Introduction to Altai linguistics]. М, p.189. 1957]
- Отгонсүрэн, Д.** (1966). *Монгол хэлний хэлзүйн найруулгын өгүүллүүд*. УБ, хуудас.6 [Otgonsuren, D. *Mongol helnii helzüin nairuulgiin ögüüllüüd*. [Articles on the grammatical stylistics of the Mongolian language]. UB, p.6. 1966]
- Өнөрбаян, Ц., Соронзон, Д.** (2019). *Монгол үгийн гарал судлалын үндэс*. УБ, хуудас.74-75 [Onurbayan, Ts., Soronzon, D. *Mongol ügiin garal sudlaliin ündes*. [Roots of Mongolian word etymology. UB, p.74-75. 2019]
- Поппе Н.Н.** (1927). *Монгольские числительные. “Языковедные проблемы по числительным”*, Л. т.1. настр.118 [Poppe N.N. (1927). [Mongolian numerals. “Linguistic problems on numerals”], L. t.1. p.118. 1927]
- Төмөртоогоо, Д** (2018). *Монгол хэлний үгийн гарлын тайлбар толь*. УБ, хуудас.18. [Tumurtogoo, D. *Mongol helnii ügiin garliin tailbar toli*. [Explanatory dictionary of Mongolian word etymology]. UB, p.18. 2018]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.